# ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2025 ОНД ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ТАЙЛАН

Өмнөговь аймаг 2025.12.10

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2025 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ |
| **3.1 ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ,ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ, ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ,ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭРХ, ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАНА.** | | | | | | |
| 3.1.1 | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийг хөтлөлтийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх дэмжин туслах багш ажиллуулан орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах | 4,000,000 | Угийн бичиг хөтлөлтийн хувь | 2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт | Угийн бичиг хөтлөлтийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичиг хөтлөлт нэмэгдсэн байна | -Аян 1, Үзэсгэлэн 3, гарын авлага 6, уралдаан 2, сургалт 138, нийт 150 арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд:<br>-“Мэдээлэлтэй автобус” аяны хүрээнд хот хоорондын үйлчилгээний 81 Алфард, Даланзадгад сумын 8 зорчигч тээврийн автобуснуудад “Угийн бичиг хөтлөх арга зүй” гарын авлагыг байршуулсан. 8 сарын хугацаанд давхардсан тоогоор 54580 хүнд, Даланзадгад, Ханхонгор, Баяндалай сумдад угийн бичгийн үзэсгэлэн гаргаж, 69 өрхийн угийн бичиг дэлгэгдэж 1539 хүнд, хөзөр, малчдын гарын авлага, “Ирээдүйгээ төлөвлөе” сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах зэрэг 6 төрлийн гарын авлагыг боловсруулж 5230 хүнд, Баян-Овоо сум “Угийн бичгээ хөтлөн-Удмын сангаа хамгаалъя” уралдаан, “Шилдэг угийн бичиг-2025” улсын уралдаан зэрэг 2 төрлийн уралдаан зохион байгуулж 143 хүнд, Зөвлөгөө өгөх төвүүд, эцэг эхийн зөвлөлүүдээр дамжуулан 138 удаагийн сургалтыг зохион байгуулж 5832 хүнд хүрсэн.<br>-Нийт 67324 хүнд хүрсэн.<br>-Нийт 26076 өрхийн 3368 өрх буюу 12.9 хувь нь угийн бичгээ хөтөлдөг болсон.<br>Үр дүн: 150 арга хэмжээгээр дамжуулан 67324 хүнд угийн бичиг хөтлөхийн ач тусыг таниулж, нийт өрхийн 12.9 хувь нь гэрийн угийн бичгээ хөтөлдөг болсон нь өмнөх оноос 9.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэрэгжсэн. |
| **3.1.2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар** | | | | | | |
| 3.1.2.1 | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 5,190,000 | -Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө<br>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг зөрчлийн бууралтын хувь | 2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоож арилгах арга хэжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хэрэг зөрчлийн хувь буурсан байна. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 4/08 дугаар тогтоолоор 2025-2028 онд хэрэгжүүлэх "Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллыг сайжруулах” 4 жилийн хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 18 ажил, арга хэмжээтэйгээр батлуулж 98 хувьтай хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Гэр бүлийн тухай” хуулиудыг сурталчлах зорилгоор 1 аян, 6 төрлийн арга хэмжээ, 2 төрлийн гарын авлага, 109 удаагийн сургалт, 7 постер, 10 цуврал нэвтрүүлэг, нийт 135 удаагийн арга хэмжээнд танхимаар 68459, цахимаар 23453, нийт 91912 хүнд хүрсэн. Мөн 12 ТББ-тай хамтран гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах чиглэлээр 36 төрлийн нөлөөллийг ажлыг зохион байгуулсан. Насанд хүрээгүй хүнд гэр бүлийн боловсрол олгох зорилгоор “Ирээдүйгээ төлөвлөе” цуврал сургалтыг зохион байгуулсан. 84 удаагийн гэр бүлийн боловсрол олгох сургалтад Даланзадгад сумын Ерөнхий боловсролын долоон сургуулийн 6-11 ангийн 4908 сурагч хамрагдсан.<br>Үр дүн: Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил хамгааллыг гэр бүлд суурилсан хэлбэрээр төлөвлөн хэрэгжүүлж, хамтарсан баг, анхан шатны нэгжүүдийн уялдаа холбоог хангаан, зорилтод бүлгийн иргэдэд хамгааллын хариу үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэн, гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгжийн оролцоог хангаан оролцсон. Хөтөлбөрийн хэрэгжилтийн зорилтот түвшнийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг зөрчил 2024 онд 123 бүртгэгдсэн бол энэ онд 94 бүртгэгдэж 29 нэгж буюу 23,6% буурсан үзүүлэлттэй байна.<br><br>Хэрэгжсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2.2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт мэдээлэл, сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 3,000,000 | -Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>-Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийн бууралтын хувь | 2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо | Сургалт мэдээлэл сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулж хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанар сайжирч, гэмт хэрэг зөрчил буурсан байна. | “Мэдээлэлтэй автобус” аяныг өрнүүлж хот хоорондын зорчигч тээврийн 81 Алфард, Даланзадгад сумын зорчигч тээврийн 8 автобусанд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн тухай” хуулиудыг сурталчлах гарын авлагыг, тухайн зорчигч сонирхон уншихуйц хэлбэрээр хийж суудал бүрд байршуулан ажиллалаа.<br>8 сарын хугацаанд давхардсан тоогоор 54580 хүнд, Өсөлттэй Даланзадгад хөтөлбөрийн "Хотын 7 хоног" арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан "Малчдын зөвлөгөөн"-д оролцож буй 100 малчин өрхөд, “Удам залгасан залуу малчин” арга хэмжээнд оролцож 60 малчин өрхөд, 4 удаагийн “Нээлттэй өдөрлөг”-т оролцож 3612 иргэнд, нийт 6 төрлийн арга хэмжээний хүрээнд 3772 иргэнд гарын авлага тараасан. Хуулиудыг таниулсан хөзөр 2000 ширхгийг малчдад зориулсан гарын авлага 1400 ширхгийг бэлтгэн тараасан. “Зөвлөгөө өгөх” төвүүдээр дамжуулан 88 удаагийн сургалтад 5626 иргэн, эцэг эхийн зөвлөлүүдээр дамжуулан 21 удаагийн сургалтад 1081 иргэн, нийт 109 удаагийн сургалтад 6707 хүн хамрагдсан. Хүчирхийллийн хор уршгийг таниулсан 7 төрлийн постер бэлтгэн 16583 хүнд, 10 цуврал нэвтрүүлэг бэлтгэн 6870 хүнд, нийт 23453 хүнд хүрсэн.<br>Үр дүн: Гэр бүлийн хүчирхийллийн төрөл, хор уршгийн талаар 135 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 91912 хүнд хүргэсэн. Энэ нь нийт иргэдэд 100 хувь хүрсэн үзүүлэлттэй байна.<br>Мөн энэ онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг 15 бүртгэгдэж өнгөрсөн онтой харьцуулахад 2 нэгжээр буурсан, зөрчил 59 тохиолдол бүртгэгдэж 4 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна<br><br>Хэрэгжсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2.3 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ амьдрах ухааны боловсрол олгох | 90,000,000 | Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | - | Орон нутгийн төсөвт урсгал зардал үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусган аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанар нэмэгдсэн байна. | - Гэр бүлд зөвлөгөө өгөх 2 төвөөр дамжуулан 3077 хүүхэд, 1503 насанд хүрэгч, нийт 4580 иргэнд зөвлөгөө өгсөн. Ганцаарчилсан зөвлөгөөнд 2478 иргэн, бүлгийн зөвлөгөөнд 2093 иргэн, хосын зөвлөгөөнд 9 иргэнийг тус тус хамруулсан. Зөвлөгөө өгөх 2 төвөөр 1610 эрэгтэй, 2970 эмэгтэй үйлчилгээ авсан.<br>-Нийт 6 төрлийн үйлчилгээнд 41 иргэнийг холбон зуучилсан. Үүнд:<br>- Эрүүл мэндийн үйлчилгээнд 4 иргэн,<br>- Эрх зүйн үйлчилгээнд 8 иргэн,<br>- Хүүхэд хамгааллын үйлчилгээнд 16 иргэн,<br>- Хөдөлмөрт зуучлалд 3 иргэн,<br>- Нийгмийн халамжийн үйлчилгээнд 9 иргэн,<br>- Залуучуудын хөгжлийн төвд 1 иргэн байна.<br>-Үйлчилгээг 100 хувь үзүүлсэн.<br>Үр дүн: Нийт 4580 иргэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн буюу нийт өрхийн 17.6 хувьд хүрсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.2.4 | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж батлуулах | | 1. Батлагдсан төсөв 100%<br>2. Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | 2024 онд баталсан төсөв | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж аймгийн ИТХ-ар батлуулсан байна. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанар нэмэгдсэн байна. | Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулган 180,0 сая төгрөг зарцуулж ажилласан.<br>89 гэр бүлийн 142 хүүхэд 35 насанд хүрэгч, нийт 177 хүнд 2549 хүн/өдрийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:<br>0-5 насны 41, 6-10 насны 39, 11-15 насны 43, 16-18 насны 19, 19-24 насны 11, 25-34 насны 16, 35-44 насны 6, 55-64 насны 2, үүнээс эрэгтэй 54, эмэгтэй 88 хүүхэд үйлчилгээ авсан.<br>Хүчирхийллийн төрлөөр нь авч үзвэл:<br>-Бие махбодын 14, Үл хайхрах 68, Бэлгийн 9, Сэтгэл санааны 37, Бусад 14 хүүхэд байна.<br>-Төрсөн эцэг нь 96, Хойд эцэг 19, Хөндлөнгөөс 7, Өөрийгөө гэмтээсэн 2, Төрөл садны зүгээс 8, бусад 10 хүүхэд байна.<br>-Эмнэлгийн үйлчилгээ 32, Сэтгэлзүйн 177, Боловсролын 85, Нийгмийн халамжийн 51, Эрхзүйн 35, Аюулгүй байдлын хамгаалалт авсан 177 үйлчлүүлэгч байна.<br>-Бие махбодын хүчирхийлэлд өртсөн 3 насанд хүрэгч, 1 хүүхэд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 9 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийг Шүүх эмнэлэгт үзүүлж дүгнэлт гаргуулсан.<br>-MNS 6040:2019 стандартын 9 зүйлийн 90 заалтын хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.<br>Үр дүн: Орон нутгийн төсвийн 180,0 сая төгрөгийн төсвөөр стандартын шаардлага хангасан байранд хүчирхийллийн хохирогч 177 иргэнд 7 төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлж, аюулгүй байдлыг ханган ажиллаж, стандартын хэрэгжилтийн зорилтот түвшнийг 9.9 хувиар нэмэгдүүлсэн<br><br>Хэрэгжсэн. |
| **3.1.3 Хүүхдийн эрхийн талаар** | | | | | | |
| 3.1.3.1 | Хүүхдийн эрх хамгааллын салбар дундын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх | | 1.Төлөвлөгөө өг баталсан эсэх<br>2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачилгыг хэрэгжүүлэн 4 зорилго, 17 үйл ажиллагааг төлөвлөн батлуулсан.<br>Төлөвлөгөөний үр дүнд хүүхдийн эрх хамгааллыг сайжруулах, хөгжил оролцоог нэмэгдүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2025 оны 04 сарын 11-ний өдрийн 5/10 дугаар тогтоолоор салбар дундын байгууллагуудыг хүүхдийн эрх, хөгжил хамгааллын асуудлыг тэргүүнд тавьж ажиллахыг үүрэг болгосон. Үүнд:<br>-Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээг үзүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг 7 төрлөөр зохион байгуулж танхим болон цахим бусад хэлбэрээр 318400 хүнд хүрсэн байна. Тухайлбал “Электрон тамхинаас татгалзаж ирээдүйгээ хамгаалцгаая” сарын аянд 35,426 хүн, “Ангиараа үлгэрлээд ангиараа амаръя” нөлөөллийн арга хэмжээнд 278,400, “Тэгш оролцоо-хязгааргүй боломж” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах сургалтад 65 хүн тус тус хамрагдсан. Мөн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авч буй 175 хүүхдийг хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд холбон зуучилж хумс гоо зүй, робот инженерчлэл, бие хамгаалах урлаг зэрэг сургалтуудад хамруулан ажилласан. 2 аян, 38 удаагийн сургалт, 1 тоглолт, 2 нээлттэй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаалганы өдөрлөг, 28 арга хэмжээ, 8 төрлийн гарын авлага, 11 постер бэлтгэн хамгааллын хариу үйлчилгээ шаардлагатай иргэдэд 100 хувь хүргэж ажилласан.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.3.2 | Төр хувийн хэвшлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж хүүхдийн авьяас чанарыг хөгжүүлэх | 1,785,728.6 | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | 2024 онд хамрагдсан хүүхдийн тоо | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо хувиар өссөн байна. | -“Монгол наадгай ба пионер багачууд” уралдааныг хоёр үе шаттай зохион байгуулж, 1 дүгээр шатанд 31 цэцэрлэгийн 7890 хүүхдийг, 2 дугаар шатанд 9 сумын 20 цэцэрлэгийн 3906 хүүхдийг оролцуулсан.<br>-Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохилдуулан Ерөнхий боловсролын сургуулийн дунд Монгол ардын уламжлалт дуу бүжгийг сурах, хөгжүүлэх өвлөн дуулж бүжиг “Дуулан бүжье” наадам зохион байгуулж нэгдүгээр шатанд 23 сургуулийн 5400 сурагч, 2-р шатанд шалгарсан хүүхдүүдийн “Хүүхэд-Хайр-Ирээдүй” 150 хүүхдийн тоглолт, Ардын бүжгийн “Ботгохон чуулгын тайлан тоглолтыг зохион байгуулж 240 хүүхэд,<br>- Хүүхэд залуучуудад Монгол ёс заншил, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор “Оскар-2025” арга хэмжээнд 8 сургуулийн 80 хүүхэд,<br>-Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн тоглолтод 2000 хүүхдийн парад жагсаал, 300 хүүхдийн урлагийн тоглолт, гэрэл зургийн үзэсгэлэн, 3 үеийн уулзалтын илэрхийлэлтэд 100 хүүхдийг,<br>-Хүүхэд, өсвөр үеийнхэнд эх оронч хүмүүжил, өөртөө итгэх итгэл, бие бялдрын хөгжил, багаар ажиллах чадвар, тэвчээр хатуужил олгох зорилгоор аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, Аймгийн ЦГ, Зэвсэгт хүчний 0167 дугаар анги, Хилийн цэргийн 0131 дүгээр анги, "Буянт хотхон" УТҮГ, Улаан загалмайн салбар хороотой хамтран “Буянт хотхон” хүүхдийн зусланд 160 хүүхэд,<br>-“VOLUNTEER SHARING-2025” Цовоо хөөрхөн дэгдээхэй ТББ-тай хамтран ЕБСургуулийн 7–12-р ангийн 1000 хүүхдийн өдөрлөг<br>-Хөдөлмөр зусланг Хадатын рашаан хэмээх газар малчин, тариаланч Н.Батнямын өрхийг түшиглэн зохион байгуулсан. Ээлж тус бүрт 2 чиглүүлэгч багш томилогдож ажилласан бөгөөд тэдгээр багшийг зуслангийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хүүхэдтэй харилцах арга зүй, хүүхэд хөгжүүлэх эрэг арга мөн зуслангийн өдөр тутмын үйл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах сургалтад хамруулж 7 ээлжид 8-17 насны нийт 175 хүүхдийг тус тус хамруулж нийт 21271 хүүхэд буюу нийт хүүхдийн 75%-д хүрч ажилласан байна.<br>Үр дүн: 9 заалтыг хяналтад 22 арга хэмжээнд 21271 хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулан цахимаар 40,862 хүнд хүрсэн байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.3.3 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах | | Баталсан төсөв | 2024 онд баталсан төсөв | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг Гурван сайдын хамтарсан А/236, А/189, А/80 тушаал тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023-2026 онуудад хэрэгжүүлэхээр 4 зорилт, 35 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 онд 3,120,000 төгрөгийн төсвийг төлөвлөн зарцуулсан байна. Үүнд:<br>-“Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалтын хүрээнд 32 удаагийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээ, 4 удаагийн рийл бичлэг, нийт 36 үйл ажиллагаа зохион байгуулж, танхимаар 1512, цахимаар 4170 хүнд хүрсэн.<br>-18 хүүхэд харах төвийн 24 багш ажилтанд “Бага насны хүүхдийн цогц хөгжил” 4 удаагийн сургалт,<br>-Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүдийн ажлын төлөвлөгөөнд бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийнх нь төрсөн өдрөөр 1 өдрийн цалинтай чөлөө олгох талаар саналыг тусгуулж, 34 байгууллага нэгдсэн. Бага насны хүүхэдтэй ажилтанд ажлын цагийн хөнгөлөлт үзүүлж буй 23 байгууллага байна.<br>Хүүхэд нь өвчилсөн бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд 5 хоногийн цалинтай чөлөө олгох шийдвэрийг сурталчлан 54 байгууллага дээрх шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан.<br>-15 сумын 34 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багт 6 чиглэлээр хяналт шалгалт хийж, 182 албан хаагчид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.<br>Үр дүн: Тайлант хугацаанд “Бага насны хүүхдийн цогц хөгжил” хөтөлбөрийн хүрээнд нийт 36 үйл ажиллагаа зохион байгуулж танхимаар 1512, цахимаар 4170 хүнд, 34 байгууллагад төрсөн өдрийн цалинтай чөлөө, 23 байгууллагад ажлын цагийн хөнгөлөлт, 54 байгууллагад хүүхэд өвдсөн үед 5 хоногийн чөлөөг хэрэгжүүлж, мөн 15 сумын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 34 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багт хяналт шалгалт хийж 182 албан хаагчид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.3.4 | Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | | Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100% хангасан байна. | -Байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх 165 эцэг эхийн зөвлөлд аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж, мэдээлэл хүргэсэн.<br>Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 5/10 дугаар тогтоолоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх заалтын дагуу аж ахуй нэгжийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн хөгжил хамгаалал, гэр бүлийн тогтвортой байдлыг хангахад зарцуулдаг тогтолцоог бий болгон ажиллахыг Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүрэг өгч, чиглэл хүргүүлсэн.<br>2025 онд орон нутгийн хэмжээнд165 эцэг эхийн зөвлөл ажиллаж байгаа бөгөөд байгууллагын төсвийн тодорхой хувийг ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхэд хамгааллын асуудалд төсөвлөн зарцуулж байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.3.5 | Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах шийдвэр гаргах түвшинд | | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | - | Хүүхдийн оролцооны байгууллагын ажиллагаа сайжирсан байна. | “Өнөөдрийн оролцоо-Маргаашийн ирээдүй” аймгийн хүүхдийн чуулганд аймгийн 15 сум, 22 сургуулийн хүүхэд, өсвөр үеийнхэн болон хүүхдийн оролцооны байгууллагууд болох Хурдан сиот клуб, Улаан загалмай, Өсвөрийн сэргийлэгч, Скаутын холбоо, Өсвөрийн сэтгүүлчдийн клубын гишүүд нийт 700 хүүхэд оролцсон. Чуулганы үйл ажиллагаанд урилгаар Монголын хүүхдийн зөвлөл, ОУХНайрамдал цогцолборын бүлгийн багш нар, контент бүтээгч Г.Нямдаваа, Аймгийн Засаг даргын орлогч нар оролцож хүүхдүүдийн санал санаачилгыг сонсон 2 саналыг хүлээлгэн өгснийг гардаж аван 2026 оны төсөвт боловсролын чиглэлээр 92,6 тэрбум төгрөг, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр 2,2 тэрбум төгрөг тус тус батлагдаад байна.<br>Мөн хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, тогтмолжуулах зорилгоор Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газарт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдийн оролцоог ханган ажиллах | | | | | хүүхдийн өөрөө удирдах байгууллагын өрөөг тохижуулан хамтран ажиллаж байна.<br>**Үр дүн:** “Өнөөдрийн оролцоо-маргаашийн ирээдүй” аймгийн хүүхдийн чуулганыг 15 сумын 24 сургуулийн нийт 700 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Чуулганы төлөөлөгчдийн санал хүсэлтийг шат дараатайгаар хэрэгжүүлж 2026 оны аймгийн төсөвт суулгасан. Мөн Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж өрөө тасалгааг шийдвэрлэсэн ба тус байгууллагуудаар дамжуулж хамтран ажиллан 15 үйл ажиллагааг зохион байгуулсан байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.3.6 | Олон нийтийн байцаагчийг ажиллуулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх | | Олон нийтийн байцаагчийн тоо Илрүүлсэн хүүхдүүдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнө оноос 50%хувиар өссөн байна. | Даланзадгад сумын 10 баг, Манлай 1, Гурвантэс 1, Цогт-Овоо 1, Цогтцэцийд 2 хүүхэд хамгаалагч ажиллаж байна. Хүүхэд хамгаалагчид нь 1200 удаагийн эргүүл хийсэн байна. Эргүүл хяналтын явцад илэрсэн гудамж талбай, гэр хорооллын эрсдэл бүхий нөхцөл байдлуудыг илрүүлж шийдвэрлэсэн 82 зөрчил байна. Олон нийтийн арга хэмжээний үеэр төөрсөн 3 хүүхдийг олж эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн. Мөн хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд эрсдэлд байгаа 46 хүүхдийг илрүүлж, хүүхэдтэй холбоотой дуудлага мэдээлэл дээр цагдаагийн алба хаагч, хүүхэд гэр бүлийн мэргэжилтнүүд, сум, багийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаж 27 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, зөвлөн тусалж ажилласан.<br>Үр дүн: Хүүхэд хамгаалагч нар хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд 1200 удаагийн эргүүл хяналтыг хийж, 82 зөрчлийг илрүүлж, холбогдох байгууллагад хүргүүлсэн. Эрсдэлд байгаа 46 хүүхдийг илрүүлж, холбогдох байгууллагад мэдээлсэн. Хүүхэд хамгаалагч нарыг ажиллуулснаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, шаардлагатай арга хэмжээ авсан үзүүлэлт 61%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br><br>Хэрэгжсэн. |
| **3.1.4 Хүүхэд хамгааллын талаар** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.1 | Хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлан таниулж салбар бүрд мөрдүүлэх | | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллага | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр хувийн хэвшил байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлого мөрдүүлсэн байна. | -2025 онд төрийн байгууллагын дэргэд 6, аж ахуй нэгжийн дэргэд 6, нийт 12 зөвлөл шинээр байгуулагдаж нийт 165 эцэг эхийн зөвлөл ажиллаж байна. 165 эцэг эхийн зөвлөлөөс 133 нь буюу 80.6 хувь нь Хүүхэд хамгааллын бодлогоо батлан мөрдөж байна. Шинээр 20 байгууллага "Хүүхдийн өрөө"-г тохижуулсан байна. "Хүүхэд эрхэм хэрэглэгч" аяны хүрээнд 5 сумын хэмжээнд 15 тоглоомын төв, 53 дэлгүүр буюу 68 хувийн хэвшил, 7 байгууллага аж ахуй нэгж, нийт 75 байгууллага шинээр хүүхэд хамгааллын бодлогоо батлан мөрдөж байна.<br>Үр дүн: Эцэг эхийн зөвлөлүүдийн тоог 12-оор нэмэгдүүлэн 165 эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан 41 арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор танхимаар 21162 хүнд, цахимаар 82416 хүнд хүрсэн. Нийт эцэг эхийн зөвлөлүүдийн 80,6 хувь нь хүүхэд хамгааллын бодлоготой байгаа нь зорилтот түвшинд хүрч 20 байгууллага хүүхдийн өрөөг шинээр тохижуулсан нь зорилтот түвшнээс 3-нэгжээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.4.2 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд үрчлэгдсэн хүүхэд бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж мэдээллийн санд бүртгэх шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хангах | | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардлагатай хүүхэд бүрд кэйс нээж үйлчилгээг бүрэн хангасан байна. | 2025 онд хүүхэд хамгааллын үйлчилгээнд давхардсан тоогоор 16594 хүүхэд хамрагдсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан нийт хүүхдүүдээс бүтэн өнчин болон үрчлэгдсэн 208 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийснээс хагас бүтэн, үрчлэгдсэн 186 хүүхдэд кейс нээн мэдээллийн санд бүртгэн, хамгааллын үйлчилгээг 100 хувь хүргэн ажилласан байна.<br>Үр дүн: Үрчлэгдсэн болон бүтэн өнчин 208 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд хамруулан амьдралын орчин нөхцөлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж кейс төлөвлөгөөгөөр хүүхэд бүрд бүрэн хүрч ажилласан.<br><br>Хэрэгжсэн. |
| | | | | | | Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны жилийн ажлын төлөвлөгөөнд эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн өмгөөллийн үйлчилгээний зардалд 30 сая төгрөг зарцуулахаар тусгаж, хүүхдийн мэргэшсэн 1 өмгөөлөгчтэй 15 сая төгрөгөөр нэг жилийн хугацаанд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бүх хүүхдэд хууль эрх зүйн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хангах | | 1.Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв<br>Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхэд эзлэх хувь | 26,7 хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан шаардлагатай хүүхэд | өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр гэрээлэн санхүүжилтийг олгож өмгөөлөгчтэй болон хорооны бүх гишүүдтэй хувь хүний нууцыг хамгаалах чиглэлээр нууцын гэрээ байгуулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой гэрээт өмгөөлөгч 2025 оны байдлаар 3 хүүхдийг өмгөөлсөн. Байгууллагын хүүхэд хамгааллын зардлаас 6 хүүхдийн өмгөөллийн зардлыг шийдвэрлэн хүүхдийг мөрдөн байцаах, шүүх хуралд оролцох тохиолдол бүрд өмгөөлөгч оролцуулж, 25 хүүхдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль ёсны төлөөлөгч байлцуулж, тохиолдол бүрд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулан ажилласан.<br>Цагдаагийн газарт шалгагдаж байгаа гэмт хэргийн сэжигтэн 10 хүүхэд, гэмт хэргийн хохирогч 35 хүүхэд үүнээс бэлгийн 10, бие махбодын 8, бусад төрлийн 17 хохирогч хүүхэд бүртгэгдсэн байна. Зөрчил үйлдэж шийтгүүлсэн 48 хүүхэд, зөрчлийн хохирогч 19 хүүхэд үүнээс бие махбодын 8, сэтгэл санааны 4, үл хайхрах 7, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ХЭХЗХ-ны ажлын албанаас хууль ёсны төлөөлөгч томилогдон кейс нээн ажилласан 25, нийт 137-н хүүхдийг бүртгэж давхардсан тоогоор 325-н хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Үр дүн: Нийт хороонд бүртгэлтэй 137 хүүхдэд давхардсан тоогоор эрүүл мэндийн үйлчилгээ 104, боловсролын үйлчилгээнд 2, нийгмийн халамжийн үйлчилгээнд 2, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 124, хууль эрхзүйн үйлчилгээнд 28, хөгжлийг дэмжих үйлчилгээнд 10, Гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч, холбогдогч болсон хүүхдүүдэд хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ үзүүлсэн 26, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 25-н хүүхдэд шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажилласан.<br><br>Хэрэгжсэн. |
| | | | | | Хурдан морины | -Аймгийн хэмжээнд 15 сумын наадам, үсэргээ, сунгаа, ойн 27 уралдаанд 100 хувь хяналт тавьж 1996 морьдыг 939 хүүхэд унаж уралдсан бөгөөд able программ дээр бүртгэж хяналт тавьж ажилласан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.4 | Хурдан морины уралдаан морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд аюулгүй байдлыг хангаж хяналт тавих | 448.887.8 | Хяналт шалгалтын тоо Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэл тийн хувь | - | уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95% хангагдсан байна. | Хурдан морь унаж уралдсан 939 хүүхдээс 5 хүүхэд мориноос унасан ба бэртсэн хүүхэд байхгүй.<br>Хөдөлмөр эрхлэгч хүүхэдтэй холбоотой зөрчил байхгүй.<br>-Цагдаагийн газартай хамтран Даланзадгад сумын 1-10-р багуудын нутаг дэвсгэрт байрлаж буй авто угаалга-12, кофе шоп-2, cu-4, барилга-7, тоосгоны-2 үйлдвэрт нийт 27 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийсэн. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхэлж буй 31 хүүхэд байгаа бөгөөд улирлын чанартай авто угаалгын газарт ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэгч 31 хүүхдэд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг танилцуулж зөвлөгөө өгч ажилласан. Хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлснээс хойш хүүхдүүд бүгд ажиллахаа больсон.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.4.5 | Гамшиг онцгой байдлын үе ган зуд үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа мэдээллийг нэгтгэн гаргаж салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | | Үйлчилгээ авсан өрхийн тоо,хүүхдийн тоо | MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал , ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагаа ны нийтлэг шаардлага | Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | Аймгийн нутаг дэвсгэрт Улаан бурхан халдварт өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын А/297 дугаар захирамжийн дагуу худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл 30 хүнд, тоглоомын төвийн 15 хүнд, ЕБС-ийн 2 дотуур байрны 178 хүүхэд, 45 аж ахуй нэгж, 220 хүүхдэд тус тус зөвлөмж, мэдээлэл өгсөн. Мөн эрсдэлт нөхцөлд байгаа 20 өрхийн 50 хүүхдэд түргэвчилсэн үнэлгээ хийсэн. Сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээг 10 насанд хүрэгч, 30 хүүхдэд өгсөн. Боловсролын үйлчилгээнд 3 хүүхдийг, эрүүл мэндийн үйлчилгээнд 2 насанд хүрэгч, 12 хүүхдийг, хууль эрхзүйн үйлчилгээнд 5 хүүхдийг тус тус холбон зуучилсан. 7 төрлийн 50 багц, 350 ширхэг шаардлагатай эд материалыг тарааж ажилласан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 4 постер бэлтгэн, пейж хуудсанд байршуулж 5200 хүний хандалт авсан. Гал түймэрт өртсөн 2 өрхийн 5 хүүхдийг хяналтад авч хувцас, хичээлийн хэрэгслийн, хүчтэй салхины улмаас гэр нь нурсан, дээвэр нь нурсан 2 өрхийн 4 хүүхдэд хүнс, хичээлийн хэрэгсэл, хувцасны дэмжлэг үзүүлсэн байна. Нийт 102 насанд хүрэгч, 507 хүүхдэд хүрч ажилласан. Цахим хандалт 5200<br>Үр дүн: Нийт 102 насанд хүрэгч, 507 хүүхдэд зөвлөмж хүргэж, 4 төрлийн үйлчилгээнд холбон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зуучилж, 4 өрхийн 9 хүүхдэд дэмжлэг үзүүлж, 350 ширхэг шаардлагатай эд материалыг эрсдэлд орсон өрхүүдэд тараасан.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.4.6 | Хүүхдийн тоглоомын талбай орон сууцны гэрэлтүүлэг цахилгаан сүлжээний аюулгүй байдал замын далан ухсан нүх суваг шуудуу траншей худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж шаардлагатай засвар үйлчилгээг хийх анхааруулах тэмдэг байршуулах хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илрэх зөрчлийг арилгаж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | Хүүхэд хамгаалагчид 380 удаагийн эргүүл хяналтыг хийсэн. Эргүүл хяналтын явцад гудамж талбай, гэр хорооллын эрсдэл бүхий нөхцөл байдлуудыг илрүүлж арга хэмжээ авахаас гадна олон нийтийн арга хэмжээний үеэр төөрсөн 1 хүүхдийг олж эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн. Мөн ерөнхий боловсролын 6 сургууль дээр нийт 80 удаа эргүүл хийсэн байна. Хүүхэд хамгаалагчид 380 удаагийн эргүүл хяналтыг хийсэн байна.<br>Хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд гарсан хүүхэдтэй холбоотой дуудлага мэдээлэл дээр цагдаагийн алба хаагч, хүүхэд гэр бүлийн мэргэжилтнүүд, сум, багийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаж 4 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, 25 зөрчил илэрснийг шийдвэрлэсэн.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.1.4.7 | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан байна | - | Хүүхдийн эрхийн зөрчлөөс байгууллагын үйл ажиллагааны хаах хязгаарлах арга хэмжээ авч хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна. | Хүүхдийн эрхийн улсын байцаагч 2025 онд 10 төрлийн хяналт шалгалтыг 131 газарт хийж албан шаардлага -5, зөвлөмж-5, дүгнэлт- 9 тус тус гаргаж холбогдох газарт хүргүүлж ажилласан байна.<br>-Төлөвлөгөөт хяналт шалгалт 89% хувьтай хэрэгжсэн. БТСГ, Гурвантэс сум, Хүрмэн сум, Цогтцэций сумын 2-р сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа, Цогтцэций сумын хамтарсан багт хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлаар 5 албан шаардлага хүргүүлсэн. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 2 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээн ажиллаж нийт 400,000 мянган төгрөг торгууль оногдуулсан.<br>-ХНХХЯам, ХГБХХЕГазраас зохион байгуулсан Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад 2 хүн хамрагдаж үнэмлэх, тэмдгээ авсан.<br>**Үр дүн:** 2025 онд Хүүхдийн эрхийн улсын байцаагчид нийт 131 газарт 10 төрлийн хяналт, шалгалт хийж, төлөвлөгөөт хяналт 100 хувиар хэрэгжиж, 18 сүм хийд, 18 сургалтын төв, 18 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхэд харах үйлчилгээ, 1 зуслан, 1 сургуулийн хүүхэд хамгааллын баг, 19 худалдаа үйлчилгээний төв, 10 теннис-билльярд төв, 12 авто угаалга, 2 кофе шоп, 4 CU, 7 барилга, 2 тоосны үйлдвэр, хурдан морь болон тэмээний уралдаан, Соёл спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах журмын дагуу 11 тэмцээн уралдааны үйл ажиллагааг хянан, 5 албан шаардлага, 5 зөвлөмж, 9 дүгнэлт гаргаж, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 2 гомдолд зөрчлийн хэрэг нээж 400,000 төгрөг торгууль ногдуулсан.<br>Дээрх үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн эрхийн зөрчил өнгөрсөн онтой харьцуулахад 3 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна<br><br>Хэрэгжсэн. |
| **3.2 ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭРХ, ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | |
| **3.2.1 Хөдөлмөрийн харилцааны талаар** | | | | | | |
| 3..2.1.1 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | 2,322,587.5 | Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо | Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Хөдөлмөрийн тухай хууль болон ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ажил олгогч, ажилтан болон иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд төлөвлөгөөт болон захиалгат сургалтыг “Ажил олгогч, ажилтны хууль эрх зүйн мэдлэгийг хамтдаа сайжруулъя” сэдвийн хүрээнд Жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг 35 ААНБ-ын 50 ажилтан, Боловсролын салбарын 18 байгууллагын 25 албан хаагч, 15 сумын ХАБЭА-н салбар зөвлөлийн 70 ажилтан, Даланзадгад сумын 1-р багийн 60 иргэн, Зэвсэгт хүчний 167-р ангийн 35 ажилтан, “Гүний ус” ХХК-ийн 30 ажилтан, ГИХГ-ын 20 албан хаагч, Тээвэр, ложистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 35 ААНБ-ын 42 ажилтан нийт 107 ААНБ-ын 332 иргэнд сургалт зохион байгуулж ажилласан. Үүний үр дүнд ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголт нэмэгдэж хуулийн хэрэгжилт хангагдаж байна.<br><br>Хэрэгжсэн. |
| | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, | | | | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1.2. | үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | 1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо | - | аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна. | Хувийн хэвшлийн жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа явуулдаг 50, тээвэр ложистикийн үйл ажиллагаа явуулдаг 35, нийт 85 ААНБ-ын 2250 ажилтанд Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг сурталчлах мэдээлэл сургалтыг 15 удаа зохион байгуулсан. Сургалт арга хэмжээний үр дүнд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн талаарх ойлголт хандлага нэмэгдэж хуулийн хүрээнд ААНБ-ууд үйл ажиллагаа эрхэлж байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.1.3. | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | | Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо | Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах хороонд хөдөлмөрийн эрхийн маргаан 14, сонирхлын маргаан 6, шүүхээс нотлох баримт шаардсан 5 хүсэлт ирсэн бөгөөд ХЭМЗХ нийт 25 удаа дүрэмд заасан хугацаанд хуралдаж, ирсэн гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Шүүх рүү шилжсэн 14 гомдол, гомдлоо буцаасан 2, эвлэрсэн 4 гомдол байна.<br>2024 онтой харьцуулахад хөдөлмөрийн эрхийн маргаантай холбоотой хүсэлт 12 нэгжээр өссөн нь иргэдийн хуулийн мэдлэг сайжирсныг илэрхийлж байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.1.4. | Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах. | | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | Бүртгэсэн хамтын гэрээ: 1<br>Зөвлөгөө өгсөн хамтын гэрээ: 19<br>Хамтын гэрээ байгуулах ач холбогдлыг таниулах сургалтыг 19 байгууллагын 26 удирдах болон төлөөлөх ажилтанд зохион байгуулсан. Боловсролын 18 байгууллага болон ХГБХХГазар хамтын гэрээний төслийг Аймгийн ҮЭ-тэй хамтран боловсруулж, зөвлөгөө өгч ажилласан.<br>2025 онд хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн хамтын гэрээ 1 нэгжээр нэмэгдэж хамтын гэрээ хэлэлцээр хийсэн байгууллага 18 болж нэмэгдсэн бөгөөд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар дээр мэдээллийн бааз үүсгэн холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Хэрэгжсэн. |

| 3.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2.1. | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах, | 2,511,528.7 | 1. Бодлогын баримт бичгийн тоо,<br>2. Судалгаа, мэдээллийн тоо | Бүсчилсэн хөгжлийн бодлого<br><br>Засгийн газрын үйл ажиллагаа ны 2024-2028 оны хөтөлбөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна. | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран тодорхойлж ажил олгогч байгууллагын 2 төрлийн судалгаа мэдээллийг гарган, мэдээллийн бааз үүсгэн ажилласан.<br>Түүнчлэн үйлдвэрийн бүсийн төлөвлөлт, дэд бүтцийг сайжруулж, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх, бизнесийн өрсөлдөх чадвар, зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг, төсөл хөтөлбөрөөр тогтвортой хөгжлийг хангах зорилготой "Нутгийн үйлдвэрлэгч" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 7/05 тогтоолоор батлуулан ажиллаж байна. Энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Өмнөговь аймгийн Засаг дарга нарын 2024 оны 240329/03-229, 2025 оны 251027/03-861 тоот "Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ"-ний дагуу "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Журамд заасны дагуу төслийн сонгон шалгаруулалтыг 3 үе шаттай зохион байгуулж, орон нутгийн 50 аж ахуй нэгж 8.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.2. | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах; | | Судалгаа, мэдээллийн тоо | Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан (EJOB систем) | Аймгийн/сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна. | Өмнөговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж “Өсөлтийг өрх бүрд” хөтөлбөрийн санхүүжилтээр “Sica” ХХК-тай гэрээ байгуулан Өмнөговь аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хүн амын бүлэг, ажил мэргэжлийн төрлөөр хийлгэж хүлээн авсан. Тус судалгаагаар ирэх 3 жилд орон нутагт эрэлттэй ажил мэргэжлийн жагсаалт болон хүний нөөцийн судалгааг салбар бүрээр гарган “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”, “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөрүүдтэй уялдуулан хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж байна.<br>Түүнчлэн өнөөдрийн байдлаар Өмнөговь аймагт нийт бүртгэлтэй болон бүртгэлгүй 38,147 ажилчин |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. Эдийн засгийн үндсэн гурван салбараар ангилан харахад үйлчилгээ болон үйлдвэрлэлийн салбарын ажилчид голлож байна. Нийт ажиллагчид: 38,147 буюу 3.1% Үйлчилгээ 15,514 буюу 2.4% Үйлдвэрлэл 12,178 буюу 4.1% Хөдөө аж ахуй 9,928 буюу 3.4%<br>Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо/ http://www.12.12/<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.3. | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | 1.Аймгийн ажилгүйдэл ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт бууралтын хувь<br>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь<br>Аймгийн ажилгүйдэл ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь | Хөдөлмөр эрхлэлт ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл<br><br>2023 он - ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59,5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56,3%, ажилгүйдлийн түвшин 5,3%,<br><br>2022 он- ядуурлын түвшин хөдөө 35,6%, аймгийн төв 26,1%, сумын төв 30,6%, хөдөө | Хүн амын бүлэг тус бүрээр судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | “Өсөлтийг өрх бүрд” хөтөлбөрийн санхүүжилтээр “Sica” ХХК-тай гэрээ байгуулан Өмнөговь аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, 40-ээс дээш настай иргэд, 35 хүртлэх насны залуучууд гэсэн хүн амын бүлгээр ажил мэргэжлийн төрөл тус бүрээр хийлгэж хүлээн авсан. Тус судалгаагаар ирэх 3 жилд орон нутагт эрэлттэй ажил мэргэжлийн жагсаалт болон хүний нөөцийн судалгааг салбар бүрээр гарган “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”, “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөрүүдтэй уялдуулан хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж байна. Мөн “Өсөлтийг өрх бүрд” хөтөлбөрийн хүрээнд<br>- Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг болон эхэлж байгаа зорилтот бүлгийн нийт 261 иргэнд тус бүр 1,0-2,0 сая төгрөгийг буцалтгүй тусламжийг, хувиараа хөдөлмөр эрхэлж, өөртөө болон гэр бүлдээ 1-2 ажлын байр бий болгож буй 40-өөс дээш насны 115 иргэдэд 5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг, 6 залууд 60 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгож ажиллалаа.<br>2025 оны 3 дугаар улирлын байдлаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 оны 3-р улирлын байдлаар 58,8 хувь болж хөдөлмөр эрхлэлтийн байдал 9,6 хувиар буурсан. Ажилгүйдлийн түвшин 2025 оны 3-р улирлын байдлаар 2,8% болж 0,9% өссөн үзүүлэлттэй байна.<br>Эх сурвалж www.1212.mn<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд 2025 онд хувиараа өрхийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 48 иргэнд 450,000.0 мянган төгрөг, Ахмадын санхүүгийн дэмжлэгт 40 иргэнд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нутаг 41,2% | | 250,000.0 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй 33 иргэнд 200,000.0 мянган төгрөг, Залуучуудыг дэмжих арга хэмжээнд 2 иргэнд 30,000.0 төгрөг, нийт 123 иргэнд 930,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноор мөн тооны ажилгүй иргэнийг өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжоор хангасан.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.4. | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | | 1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо<br>2.Холбогдох арга хэмжээний тоо<br>3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3,7%, /2023/ | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Нийгмийн халамжийн сангаас хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн 5 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, 3 иргэнд хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийлгэн https://ejob.gov.mn/ бүртгэл мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар бүртгүүлсэн.<br>Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 2 иргэнийг бэлэг дурсгал, гар урлалын чиглэлээр сургалтад хамруулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин 33 иргэнд 200,0 сая төгрөг, ахмадын санхүүгийн дэмжлэгт 40 иргэн хамруулж 250,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.<br>Өмнөговь аймгийн “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд Халамжаас хөдөлмөрт бодлогын хэрэгжилтийг хангаж зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжин нийт 261 иргэнд 388,0 сая төгрөгийн эргэн төлөлтгүй санхүүгийн дэмжлэг олгосон.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.5. | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (Job Center)-ийг орон нутагт | | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт<br>2,Холбогдох арга | - | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн биржээр дамжуулан нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн ба энэхүү үйл ажиллагааны хүрээнд Өмнөговь аймагт “Job Center” төвийг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | | хэмжээний тоо | | тоо нэмэгдсэн байна. | байгуулахаар төсөвт суугдсан ч ХХҮГ-ийн шинэ байр ашиглалтад ороогүй, засвар, шугам сүлжээний асуудал 2025 онд багтаж бүрэн шийдэгдэж дуусаагүй бэлтгэл ажлын хүрээнд “Арвин Эрдэнэ” хөдөлмөрийн биржтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.6. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжпэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжпэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажпын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | 1 .Хяналт шалгалтын тоо<br>2.Судалгаа, мэдээллийн тоо<br>3.Холбогдох арга хэмжээний тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо 30,9 мянга /2024 оны 4-р улирал/ Цалин хөлстэй ажиллагч 318,9 мян.хүн /2023/ | Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 2023-2024 онд хамрагдсан Даланзадгад сумын 29 иргэний төслийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт хийхэд төслийн зээлийг ажлын байр барих, тоног төхөөрөмж худалдан авах, бараа материал татан авах зэргээр зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд банканд зээлийн зарцуулалтын тайлан санхүүгийн баримтыг гэрээний дагуу банканд гаргаж өгсөн. Төслийн хүрээнд нийт 29 ажлын байр хадгалагдаж 12 ажлын байр шинээр бий болсон байна. Мөн ахмад, ХБИ, өрхийн үйлдвэрлэл, хуваариа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулсан ХЭДС-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт төсөл ирүүлсэн нийт 119 иргэний төсөлд урьдчилсан хяналт хийсэн.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.7. | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртөй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | | 1.Холбогдох арга хэмжээний тоо<br>2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br>3.Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загварын тоо | 2023 онд ХЭДС-аас шилдэг старт ап залуучууд ад олгох санхүүгийн дэмжлэг 139 хүнийг хамруулж, 721,0 сая төгрөг зарцуулсан. | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажпын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна. | Гарааны бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудад зориулсан шилдэг “Старт-Ап” төслийн уралдааныг аймгийн хэмжээнд нээлттэй зарлан 17 багийг бүртгэн “Нэгдмэл үйлс нэг сэтгэл” ТББ-ын сургалтын төвтэй гэрээлэн гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ын туслалцаатайгаар хөгжүүлэх 54 цагийн арга хэмжээг 3 өдөр зохион байгуулж шалгарсан 7 багийг бүлэг болгож 5 долоо хоногийн хурдасгуур хөтөлбөрт хамруулж 8,000.0 мянган төгрөгийг зарцуулсан. Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргасан “VOD” бизнесээ аваръя, “G Mars” сэтгэл зүйн төв нэртэй шилдэг 2 багийг сонгон шалгаруулж эргэн төлөгдөх нөхцөлтэй 30,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгон байнгын 5 ажлын байр бий болгосон. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэрэгжсэн. |
| 3.2.2.8. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ- тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах; | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд “Өмнөговьд үйлдвэрлэв” борлуулалтын цэгийг ажиллуулж гэрээ байгуулан ажлын байрны түрээсийн хөнгөлөлт болох 7,200.0 мянган төгрөгийг олгосон. Тус борлуулалтын цэгээр нийт давхардсан тоогоор 186 иргэний бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж 206 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.<br><br>Хэрэгжсэн. |
| 3.2.2.9. | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжпэг үзүүлж ажиллах; | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд 160,7 сая төгрөг зарцуулсан | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл нь аймгийн Засаг даргын “Өсөлттэй-Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 40-өөс дээш насны өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 115 иргэнд 591,245.0 мянган төгрөг, өрх толгойлсон 20 иргэнд 32,500.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 59 иргэнд 93,500.0 мянган төгрөг, 182 ахмадад 262,000.0 мянган төгрөг, нийт 376 иргэнд 979,245.0 мянган төгрөгийн эргэн төлөлтгүй санхүүгийн дэмжлэгийг олгож үүний үр дүнд зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн 376 шинэ ажлын байр бий болгосон.<br><br>Хэрэгжсэн. |
